

**БАЙГАЛЬ СОЁЛЫН ӨВИЙГ
ХАМГААЛАХ САН**

СОЁЛЫН ӨВИЙН ТӨВ

**СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ЧИГЛЭЛЭЭР АЖИЛЛАЖ БАЙГАА
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА БОЛОН ӨВЛӨН УЛАМЖЛАГЧДЫН
ТЭРГҮҮН ТУРШЛАГА ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНЫ БОЛЗОЛ**

Үндэслэл.

Улс үндэстэн, угсаатны бүлгийн соёлын өв нь тухайн үндэстэн, угсаатны бүлэг оршин тогтнох, бусдаас өвөрмөцөөр бодож, сэтгэх, бүтээж туурвих, амьдран хөгжих, ингэснээрээ хүн төрөлхтний соёлын олон төрлийг баяжуулан хөгжүүлж байдаг эх ундарга юм. Энэхүү амьдрал, хөгжлийн ундаргыг хайрлан хамгаалж, хөхиүлэн дэмжиж, өвлөн уламжлах нь монголчуудын төдийгүй хүн төрөлхтний нэн тулгамдсан зорилтын нэг болж байна. Дэлхийн Соёл, Боловсрол, Шинжлэх Ухааны олон улсын байгууллага ЮНЕСКО энэ нөхцөл байдлыг анхааралдаа авч “Байгаль болон соёлын өвийг хамгаалах тухай” 1972 оны конвенци, “Соёлын биет бус өвийг хамгаалах тухай” 2003 оны конвенци, “Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах, хөхиүлэн дэмжих тухай” 2005 оны конвенцийг тус тус батлан хэрэгжүүлж байгаа билээ.

Монгол улс дээрхи конвенцуудад тэр даруйд нэгдэн орсон бөгөөд Монгол улс, монгол үндэстний соёлын өвийг хадгалж хамгаалах талаар төрийн бодлого, хууль тогтоомжууд гарган хэрэгжүүлж байна.

Соёлын өв, түүний дотор соёлын биет бус өв (СББӨ)-ийг хамгаалж, өвлөн уламжлахад угсаатны Хам бүлэг, СББӨ-ийн зүйлээр дагнасан хам бүлэг, түүнд түшиглэсэн ТББ, тэрчлэн өвлөн уламжлагчид, хувь хүмүүсийн үүрэг оролцоо онцгой ач холбогдолтой юм. Монгол улсад СББӨ-ийн чиглэлээр ТББ-ууд үүсэн байгуулагдаж нэлээд идэвхтэй ажиллаж байна. Одоогоор нэгдсэн тодорхой тоо, мэдээлэл байхгүй ч баттай мэдэгдэж байгаагаар 100 орчим ТББ, мөн хэдэн мянган өвлөн уламжлагчид янз бүрийн арга хэлбэрээр үйл ажлаа явуулж байна. Гэсэн хэдий ч орон нутагт нутгийн иргэд, хам бүлгийн дотор ажиллаж байгаа ТББ (хамтлаг, холбоо, нийгэмлэг, төв, хоршоо гэх мэт) ховор байгаа нь ажиглагдаж байна.

Иймээс ЮНЕСКО-гийн батламжит ТББ - “Байгаль, соёлын өвийг хамгаалах сан” санаачлан, Соёлын өвийн төвтэй хамтран БСШУЯ, ЮНЕСКО-ийн МҮК-ийн дэмжлэгтэйгээр “Монгол улс дахь СББӨ-тэй холбоотой ТББ-ын чадавхийг бэхжүүлэх нь” төслийг хэрэгжүүлж байна. Энэ арга хэмжээний хүрээнд **2015 оны 9-р сард СББӨ-ийн ТББ болон өвлөн Залгамжлагчдын Үндэсний чуулган, сургалт семинар** зохион байгуулах бөгөөд түүнд оролцох ТББ-ын зарим төлөөллийг сонгон шалгаруулах зорилгоор **“СББӨ-ийн чиглэлээр ажиллаж байгаа ТББ болон өвлөн уламжлагчдын тэргүүн туршлага шалгаруулах уралдаан”** зарлаж байна.

Уралдааны зорилго: Монгол улсад Соёлын биет бус өв (СББӨ)-ийн зүйлийг хадгалж хамгаалах, өвлөн уламжлах, сурталчилан алдаршуулах, “СББӨ-ийг хамгаалах тухай”

ЮНЕСКО-гийн 2003 оны конвенцийг сурталчлах, хэрэгжилтийг нь эрчимжүүлэх энэ талаархи олон түмний мэдлэг чадвар, оролцоог дээшлүүлэх, түүний дотор СББӨ-ийн хам бүлэг, иргэний болон ТББ, өвлөн тээгч, уламжлагчдын идэвх санаачлага, оролцоог дээшлүүлэх зорилгоор СББӨ-ийн чиглэлээр ажиллаж байгаа ТББ болон өвлөн уламжлагчийн тэргүүн туршлагыг шалгаруулж, түгээн дэлгэрүүлэхэд уралдааны зорилго оршино.

Хугацаа: Уралдааныг 2015 оны 6 дугаар сараас 7 дугаар сарын 30-ний хооронд хоёр сарын хугацаатай зарлаж байна.

Оролцогчид: СББӨ-ийн чиглэлээр 2-оос доошгүй жил ажиллаж байгаа, Монгол Улсад мөрдөж буй хууль тогтоомжийн дагуу хуулийн этгээд болсон ТББ болон Монгол Улсын иргэн бөгөөд нэгээс дээш СББӨ-ийн зүйлийг эзэмшиж, залуу үед өвлөн уламжлуулж, хамгаалан хөгжүүлж яваа өвлөн уламжлагчид байна.

Тэргүүн туршлагын агуулга, үйл ажиллагааны чиглэлд тавигдах шаардлага.

Оролцогчид СББӨ-ийн зүйлийг олж тогтоох, баримтжуулах, эзэмших, өвлөн уламжлах, сургах, сурталчлан алдаршуулах талаарх өөрийн үйл ажиллагааны тодорхой арга хэлбэр, туршлага, түүний агуулга, арга барил, онцлог, ач холбогдол, үр дүнг үнэн зөв, тод томруун, баримт жишээн дээр тодорхойлон бичсэн байна. Тэргүүн туршлагын бичлэгт тухайн туршлагын үр дүнг тодорхой гаргаж бичнэ. Тэргүүн туршлагын агуулга нь хүний эрхийн түгээмэл тунхаглалын үзэл санаанд бүрэн нийцсэн байна.

Тэргүүн туршлага нь СББӨ-ийн дор дурдсан ай төрлийн нэгээс дээш төрлийг багтаасан байна.

Биет бус соёлын өвийн айнууд (СББӨ)

- ❖ СББӨ-ийг тээгч эх хэлийг оролцуулан аман уламжлал, түүнийг илэрхийлэх хэлбэрүүд
- ❖ Урлагийн үзүүлэх, тоглох илэрхийлэл хэлбэрүүд, ардын уламжлалт тоглоом наадгай
- ❖ Зан үйл, ёс заншил, баяр ёслолууд
- ❖ Байгаль болон ертөнцийн тухай мэдлэг, арга ухаан
- ❖ Уламжлалт гар урлал

Тэргүүн туршлага нь үйл ажиллагааны дор дурдсан чиглэлийн нэг буюу түүнээс дээш чиглэлд багтсан байна. Үүнд:

- ❖ Соёлын өвийн талаархи ЮНЕСКО-гийн болон бусад олон улсын конвенц, эрх зүйн баримт бичгүүдийг сурталчлах хэрэгжүүлэхэд оролцох, туслах
- ❖ Соёлын өвийн асуудлаар судалгаа, сурталчилгаа хийх, баримтжуулах.
- ❖ Хам бүлгийн соёлын өвийг хайж олох, тодорхойлоход оролцох

- ❖ Соёлын өвийн зүйлийг эзэмших, хүүхэд залуучуудад өвлөн уламжлуулах
- ❖ Соёлын өвийг өвлөн уламжлуулах төрөл бүрийн сургалт явуулах
- ❖ Соёлын өвийг хамгаалах зорилгоор төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах. Үүнд: энэ чиглэлээр хурал уулзалт, цуглаан сургалт, семинар, компани т ажил уралдаан тэмцээн, баяр ёслол, зан үйл, их наадам зохион байгуулах.
- ❖ Олон улсын байгууллагууд болон холбогдох мэрэгжлийн байгууллагуудтай холбогдож соёлын өвийн асуудлаар хамтарсан арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- ❖ Дэлхийн өвийн конвенцуудын жагсаалтуудад үндэсний соёлын өвөөс нэр дэвшүүлэх санаачлага гаргах, нэр дэвшүүлэх баримт бичиг боловсруулахад оролцох зэрэг байж болно.

Жич: Орон нутагт байгаа СББӨ-ийн Хам бүлэгт түшиглэсэн иргэний болоод ТББ-ын тэргүүн туршлага, мөн хүүхэд залуучуудад СББӨ-ийг өвлөн уламжлуулахад чиглэсэн тэргүүн туршлагыг илүү анхааран авч үзнэ.

Тэргүүн туршлагын бичлэгт тавигдах шаардлага:

1. Тэргүүн туршлага нь 3-аас доошгүй 5-аас илүүгүй хуудсанд багтаан олон улсын стандартын дагуу бичсэн байна.
2. Тэргүүн туршлагын агуулга, хэлбэрийг харуулсан 3-5 гэрэл зураг хавсаргасан байна.
3. Тухайн харъяалсан сум, дүүрэг (хот)-ийн засаг даргын тодорхойлолт бичгийг хавсаргасан байна.
4. Тэргүүн туршлагын үр дүн, амжилтын талаар оролцогчид, ашиг хүртсэн хүмүүсийн санаа сэтгэгдэл, саналыг хавсаргаж болно.

Уралдааны болзол.

-Уралдааныг зохион байгуулагчид таван хүний бүрэлдэхүүнтэй шүүгчдийн баг байгуулан дүгнэнэ.

-Уралдаанд дээр дурдсан шаардлагуудыг бүрэн хангасан баримт бичгийг 2015 оны 7 - дугаар сарын 30-ний дотор хүлээн авна.

-Шаардлага хангаагүй болон заасан хугацаанд ирүүлээгүй баримт бичгийг шүүгчдийн багийн үнэлгээнд оруулахгүй.

-Уралдаанд нэр дэвшүүлсэн тэргүүн туршлагын баримт бичгийг үндэслэн шүүгчдийн баг үнэлгээ хийж дор дурдсан тэргүүн туршлагыг шалгаруулж авна. Үүнд:

1. СББӨ-ийн чиглэлээр ажилладаг 10 ТББ-ын тэргүүн туршлага;
2. СББӨ-ийн өвлөн уламжлагч 10 хүний тэргүүн туршлага;
3. Тэргүүн туршлага шалгаруулах уралдаан, СББӨ-ийн өвлөн уламжлагчид болон ТББ-ын талаар хийх судалгааг тухайн аймаг, дүүрэгтээ болзол, удирдамжийн дагуу үлгэр

жишээ зохион байгуулсан 5 аймаг, сум дүүргийн Боловсрол, соёлын газрын дарга эсвэл мэргэжилтэн 5 хүнийг шалгаруулна.

Уралдааны урамшуулал

1. Уралдаанд тэргүүн туршлагаа бичиж ирүүлсэн ТББ болон өвлөн уламжлагч, бүрт “Дурсамж”, гардуулж СББӨ-ийн тухай гарын авлага ном, CD, DVD олгоно.
2. Уралдаанд тэргүүн туршлага нь шалгарсан ТББ-ын төлөөлөл тус бүр нэг, нийт 10 хүнийг; уралдаанд тэргүүн туршлага нь шалгарсан 10 өвлөн уламжлагчийг; мөн уралдааныг болон судалгааг үлгэр жишээ сайн зохион байгуулсан Боловсрол соёлын газрын дарга, эсвэл мэргэжилтэн 5 хүнийг тус тус Монгол Улс дахь СББӨ-ийн ТББ, өвлөн уламжлагчдын Үндэсний чуулган, сургалт семинарт төлөөлөгчөөр оролцох эрхийн бичгээр шагнаж, “Батламж” гардуулна.

Холбоо барих байгууллага, хаяг.

Соёлын өвийн төвийн Биет бус соёлын өвийг хамгаалах хэлтэс

Хэлтсийн дарга Ц. Жаргалсайхан утас: 99064816

И-мэйл: tsjargalsaikhan@monheritage.mn

www.monheritage.mn

Байгаль соёлын өвийг хамгаалах сан

А. Дүүрэнжаргал утас: 99158664, И-мэйл: aduurenjargal@yahoo.com

Уралдаанд баримт бичиг ирүүлэх хаяг.

Соёлын төв өргөө 2 давхарт, “*Соёлын өвийн төвийн Биет бус соёлын өвийг хамгаалах хэлтэс*”

Шуудангийн хаяг: 210620а, СБД, СБ талбай 3, Монгол улс